



**ОРХОН АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 01 дугаар сарын 20

Дугаар A/09

Жаргалант сум

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025-2028 оны стратеги
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.18 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтыг хэрэгжүүлж ажиллахыг хөгжлийн хороодод даалгасугай.

3.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг жил бүрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх, шаардагдах арга хэмжээний зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгуулах, стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хоёр жил тутам үнэлгээ хийж, дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад танилцуулахыг нарийн бичгийн дарга (Ц.Ганбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Ш.БИЛГҮҮНБААТАР

6125020009

АГУУЛГА

1. Нийтлэг үндэслэл.....
2. Алсын хараа.....
3. Эрхэм зорилго.....
4. Стратеги зорилго, зорилт.....

2. Хавсралт.....
- 2.1. Мандатын шинжилгээ.....
- 2.2. Харилцаа холбооны уялдаа.....
- 2.3. Орчны шинжилгээ.....
- 2.4. Сумын ИТХ, Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт.....
- 2.5. Чиг үүргүүд.....

4

**ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2025-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү стратеги төлөвлөгөө нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлох, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, багийн иргэдийн Нийтийн Хурлын байгууллагыг бэхжүүлэх, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, сумын эдийн засаг, нийгэм, хөгжлийн бодлогыг бие дааж шийдвэрлэх, орон нутгийн өмчийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх, төсвийн удирдлагын үр ашгийг нэмэгдүүлэх, хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангахад оршино.

ХОЁР.АЛСЫН ХАРАА

Иргэдийн оролцоонд суурилсан сайн засаглалтай нутгийн өөрөө удирдах байгууллага болно.

ГУРАВ.ЭРХЭМ ЗОРИЛГО

Оновчтой бодлогоор-Тогтвортой хөгжлийг хангана.

ДӨРӨВ.СТРАТЕГИ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

ЗОРИЛГО 1:Нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг уялдуулж, нутгийн хөгжлийн бодлого, хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангаж, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлэх, хяналтын үр дүнг үндэслэн шийдвэрийг оновчтой болгож хэвшинэ.

Зорилт.1.1:Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгнө.

Зорилт.1.2:Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхэд хянан шалгах үйл ажиллагааг хэвшүүлж, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ өгөх ажлыг тогтмолжуулна.

Зорилт.1.3:Нутаг дэвсгэрийн иргэдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэгш хангана.

ЗОРИЛГО 2:Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хуулиар олгогдсон эрх, үүргийн дагуу сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлого чиглэлийг бие даан зүй зохистой тодорхойлон шийдвэрлэж, орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, үр ашгийг дээшлүүлэх, орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлнэ.

Зорилт.2.1: Сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн дунд, богино хугацааны үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлтийг хууль тогтоомжийн хүрээнд зүй зохистой тодорхойлж, нутаг дэвсгэрийн цаг үеийн тулгамдсан асуудлуудыг шуурхай шийдвэрлэнэ.

Зорилт.2.2: Хууль тогтоомж, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрүүдийг сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.

Зорилт.2.3: Сумын өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналтыг сайжруулна.

ЗОРИЛГО 3:Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлнэ.

Зорилт.3.1:Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан, Хурлын Зөвлөл болон Хөгжлийн хороодын хуралдаанаар нийтийн эрх ашигт нийцсэн оновчтой шийдвэрийг гаргахаар хэлэлцүүлэх асуудлуудын судалгааг тогтмол хийж, шаардлага хангасан эсэхэд дүгнэлт гаргах, хуралдааны бэлтгэл зохион байгуулалтыг хангах, Хурлын дэргэдэх ГХУСАЗ

салбар зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна.

Зорилт.3.2:Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй мэдээлэх, сурталчлан таниулахад цахим технологи, дэвшилтэд арга хэрэгсэл ашиглана.

Зорилт.3.3:Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүс нутгийн болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Зорилт.3.4:Олон нийтийн үүсэл санаачилгыг дэмжих, аливаа шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

Зорилт.3.5:Цаг үеийн шаардлагад нийцсэн чадварлаг, бүтээмжит ажлын албыг бэхжүүлнэ.

Зорилт.3.6:Багийн ИНХ-ын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг, бүх талын туслалцаа үзүүлэх, ИНХ-ын үйл ажиллагааны үр нөлөө, өгөөжийг тогтвортой дээшлүүлэх.

ХОЁР. ХАВСРАЛТ

2.1.МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Сумын ИТХ-ын үйл ажиллагаанд нийтлэг мөрдөгдөж буй хуулийн жагсаалт:

1. Авлигын эсрэг хууль
2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
3. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай
4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
5. Монгол Улсын Үндсэн хууль
6. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
7. Төсвийн тухай хууль
8. Төрийн албаны тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль

Сумын ИТХ-ын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй салбар хуулийн жагсаалт:

1. Авто замын тухай хууль
2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
3. Ард нийтийн санал асуулгын тухай хууль
4. Ахмад настны тухай хууль
5. Ашигт малтмалын тухай хууль
6. Аялал жуулчлалын тухай хууль
7. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль

8. Байгалийн ургамлын тухай хууль
9. Байгаль орчныг хамгаалах тухай хууль
10. Барилгын тухай хууль
11. Боловсролын тухай хууль
12. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль
13. Газрын тухай хууль
14. Газрын төлбөрийн тухай хууль
15. Газрын хэвлий тухай хууль
16. Галын аюулгүй байдлын тухай хууль
17. Гамшгаас хамгаалах тухай хууль
18. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль
19. Гэмт, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
20. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
21. Дайчилгааны тухай хууль
22. Дархлаажуулалтын тухай хууль
23. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
24. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль
25. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль
26. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
27. Захиргааны ерөнхий хууль
28. Зөрчлийн тухай хууль
29. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль
30. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
31. Малын генетик нөөцийн тухай хууль
32. Малын тоо толгойн албан татварын тухай хууль
33. Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль
34. Монгол улсын Засгийн газрын тухай хууль
35. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль
36. Монгол улсын Их хурлын сонгуулийн тухай хууль
37. Нийгмийн халамжийн тухай хууль
38. Нийтийн сонсголын тухай хууль
39. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль
40. Ойн тухай хууль
41. Онц байдлын тухай хууль
42. Орон нутгийн хамгаалалтын тухай хууль
43. Орон сууц хувьчлах тухай хууль
44. Орон сууцны тухай хууль
45. Органик хүнсний тухай хууль
46. Соёлын тухай хууль
47. Соёлын өвийг хамгаалах тухай хууль
48. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль
49. Тариалангийн тухай хууль
50. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
51. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль
52. Төрийн албаны тухай хууль
53. Төрийн аудитын тухай хууль
54. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
55. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
56. Төрийн хяналт шалгалтын тухай хууль
57. Төрийн хэмнэлтийн тухай хууль
58. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
59. Ургамал хамгааллын тухай хууль
60. Усны тухай хууль
61. Улсын бүртгэлийн ерөнхий хууль
62. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
63. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль

- 64. Үндэсний их баяр наадмын тухай хууль
- 65. Хаягжуулалтын тухай хууль
- 66. Хог хаягдлын тухай хууль
- 67. Хоршооны тухай хууль
- 68. Хот байгуулалтын тухай хууль
- 69. Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль
- 70. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль
- 71. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- 72. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
- 73. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- 74. Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль
- 75. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль
- 76. Хүнсний тухай хууль
- 77. Хүүхдийн эрхийн тухай хууль
- 78. Хүүхэд хамгааллын тухай хууль
- 79. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль
- 80. Шилэн дансны тухай хууль
- 81. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль
- 82. Эрүүл мэндийн тухай хууль

МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		91			
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	82			
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	9			
Ерөнхий чиг үүрэг 1. Нутгийн удирдлагын хөгжлийн бодлого хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангах					
№	Үндсэн чиг үүрэг	Хуулийн нэр, заалт	Дэд чиг үүрэг (салбарын хуулийг баримжаалах)	Хуулийн нэр, заалт	Хамтран хэрэгжүүлэгч
1	Тухайн шатны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх;	ЗЗНДНТУТХ 35.1.4	Засаг даргыг томилуулахаар тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Нийтийн Хурал нэр дэвшүүлнэ	ЗЗНДНТУТХ 56.2	Ажлын алба
2	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;	ЗЗНДНТУТХ 35.1.5			Засаг даргын Тамгын газар
3	Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх Засаг даргын тайланг	ЗЗНДНТУТХ 35.1.6			Засаг даргын Тамгын газар

	хэлэлцэж, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;				
4	Хуульд заасан үндэслэлээр тухайн шатны Засаг даргыг огцруулах талаар дээд шатны Засаг дарга, эсхүл Ерөнхий сайдад санал тавих;	ЗЗНДНТУТХ 35.1.7	Засаг даргад дараах үндэслэлээр хариуцлага тооцно.	ЗЗНДНТУТХ 65.1,	-
			Хурлын шийдвэрийг хангалтгүй биелүүлсэн гэж тухайн Хурал дүгнэсэн.	ЗЗНДНТУТХ 65.1.1	-
			нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хүн амын амьдралын асуудалтай холбогдох хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж тухайн Хурал дүгнэсэн.	ЗЗНДНТУТХ 65.1.2,	-
5	Засаг даргын өргөн мэдүүлснээр аймгийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах;	ЗЗНДНТУТХ 35.1.9	Сум, дүүргийн Засаг дарга, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд өргөн мэдүүлэх.	Төсвийн тухай хууль 8.5.3	Засаг даргын Тамгын газар
			Засаг даргын болон Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих;	Төсвийн тухай хууль 64.1.1	
			Тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх	Төсвийн тухай хууль 64.1.2	
			Төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн батлах.	Төсвийн тухай хууль 64.1.3	

			Төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн талаарх Засаг даргын болон Захирагчийн мэдээллийг сонсох.	Төсвийн тухай хууль 64.1.4	
6	Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх Засаг даргын үйл ажиллагаанд хяналт тавих;	ЗЗНДНТУТХ 35.1.15	Холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, дээд шатны болон тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах талаар зохиож байгаа ажил, түүний явц, үр дүнгийн тухай Засаг дарга, өөрийн нутаг дэвсгэр дэх тухайн засаг захиргааны нэгжид харьяалагдах байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригчдын мэдээллийг сонсох, илтгэл сонсголыг хэлэлцэх.	Төрийн хяналт шалгалтын тухай хууль 12.1.1.	Засаг даргын Тамгын газар
			Дээд шатны болон тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэрийнхээ холбогдох бүх байгууллага, аж ахуйн нэгжид тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр хянан шалгах.	Төрийн хяналт шалгалтын тухай хууль 12.1.2.	
			Холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, дээд шатны болон тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангахтай холбогдуулан Хурлын	Төрийн хяналт шалгалтын тухай хууль 12.1.3.	

			төлөөлөгчдөөс тавьсан асуулт, асуулгын хариуг хэлэлцэж, шаардлагатай гэж үзвэл зохих шийдвэр гаргах.		
			Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, Хурлын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж хянан шалгах бүрэн эрхээ Засаг дарга хангалтгүй хэрэгжүүлж байна гэж үзвэл түүнийг бүрэн эрхийн нь хугацаа дуусахаас өмнө огцруулах тухай саналыг Ерөнхий сайд буюу дээд шатны Засаг даргад тавих.	Төрийн хяналт шалгалтын тухай хууль 12.1.4.	
Ерөнхий чиг үүрэг 2. Нутаг дэвсгэрийнхээ нийгэм, эдийн засгийн асуудлыг бие даан шийдвэрлэх					
№	Үндсэн чиг үүрэг	Хуулийн нэр, заалт	Дэд чиг үүрэг	Хуулийн нэр, заалт	Хамтран хэрэгжүүлэгч
7	Нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны бодлого, жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;	ЗЗНДНТУТХ 35.1.8.			Засаг даргын Тамгын газар
8	Хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;	ЗЗНДНТУТХ 35.1.10.			Засаг даргын Тамгын газар

9.	Орон нутгийн өмчийн зүйлсийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх;	ЗЗНДНТУТХ 35.1.11.	<p>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна.</p> <p>орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах;</p> <p>иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх;</p> <p>орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах. Хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалтыг батлахдаа Төрийн өмчийн хороотой зөвшилцөнө;</p> <p>орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих.</p> <p>Орон нутгийн өмчид хамаарах</p>	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 77 дугаар зүйлийн 1, 2.1, 2.2, 2.3, 2.3, 2.4, 3, 4,	Орон нутгийн өмчийн газар Засаг даргын Тамгын газар
----	---	-----------------------	--	--	--

			<p>үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын дарга шийдвэрлэнэ.</p> <p>Хурлын дарга нь тухайн хурлын хуралдааны чөлөөт цагт энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хариуцан тайлагнахаас гадна орон нутгийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд өмчийн төлөөлөгчийг томилж түүний үйл ажиллагааг чиглүүлнэ.</p>		
			Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэх;	Газрын тухай хууль 20.1.1.	Газрын алба
			Бусдын эзэмшил газрыг аймаг, сум, нийслэлийн тусгай хэрэгцээнд авахтай холбогдуулан гэрээний хугацаа дуусахаас өмнө газрыг солих буюу эргүүлэн авах тохиолдолд тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлснээр нөхөн олговор олгох шийдвэр гаргах;	Газрын тухай хууль 20.1.4.	
10	Орон нутгийн өмчит хуулийн этгээд	ЗЗНДНТУТХ 35.1.12.	Орон нутгийн өмчийг эзэмших, захиран	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай	

	байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх;		зарцуулахтай холбогдсон харилцааг энэ хуулийн тавдугаар бүлэгт заасны дагуу зохицуулна.	хууль 80 дугаар зүйл, 81 дүгээр зүйл	Орон нутгийн өмчийн газар	
			Орон нутгийн өмчийг хувьчлах арга, хэлбэр, журмыг энэ хуулийн зургаадугаар бүлэгт заасныг удирдлага болгон иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.	Төрийн хэмнэлтийн тухай хууль 10.1		
			Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.	Компанийн тухай хууль		
11	Хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын	ЗЗНДНТУТХ 35.1.14.	Энэ хуулийн 17.1-д заасан санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих журмыг тухайн шатны Хурал тогтоож, түүний хэрэгжилтэд хяналт тавина.	ЗЗНДНТУТХ 17.1, 17.2	Засаг даргын Тамгын газар	
			Тухайн орон нутгийн онцлогт тохируулж, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн	Газрын тухай хууль 20.1.6		

	бүртгэлд бүртгүүлэн мөрдүүлэх;		сэргээх журмыг батлах; Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сумын тухайн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэн багийн иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг үндэслэн малчин өрхийн анхдагч холбоонд гэрээгээр ашиглуулах бэлчээрийн зааг, хэмжээ, байршлыг тогтоох.	Газрын тухай хууль 20.1.7	
			Нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоох;	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйл	
			Тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлснийг үндэслэн газрыг аймаг, сум, нийслэлийн тусгай хэрэгцээнд авах, түүний хэмжээ, зааг, ашиглах журмыг тогтоох;	Газрын тухай хууль 20.1.3	Газрын алба
12	Худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам батлах;	ЗЗНДНТУТХ 35.1.16.			Засаг даргын Тамгын газар
13	Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэгт	ЗЗНДНТУТХ 35.1.17.	Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийг иргэдийн дунд	ЗЗНДНТУТХ 39.1.10	Төлөөлөгч, Ажлын алба

	иргэдийг татан оролцуулах, саналыг нэгтгэн хууль санаачлагчид уламжлах;		зохион байгуулж, тэдний саналыг авч, нэгтгэх.		
			Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэн хүлээн авсан.	Нийтийн сонсголын хууль 8.3.2	
14	Хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;	ЗЗНДНТУТХ 35.1.13			Ажлын алба
15	Хуульд заасан бусад бүрэн эрх	ЗЗНДНТУТ 35.1.18	Тухайн шатны Хурал орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн 05 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө нутаг дэвсгэрийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан Хурлын төлөөлөгчийн тоонд үндэслэн тойргийг байгуулж, тойрогт ногдох мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтооно.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 12.1, 12.5, 17.1	Аймгийн Сонгуулийн хороо Сумын сонгуулийн хороо
			Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хороог санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн		

			бичгийн дарга болон гурав, эсхүл таван гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ		
			Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар улсын хэмжээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, түүний биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулах;	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 17.1.2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
			Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хүний эрх, жендерийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар тухайн шатны Засаг даргын тайланг хуралдаанаараа хэлэлцэж, дүнг нийтэд мэдээлнэ.	Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль 20.2	Засаг даргын Тамгын газар
			Тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах;	Газрын тухай хууль 20.1.2	Газрын алба
Ерөнхий чиг үүрэг 3. ИТХ-ын дотоод үйл ажиллагааг зохион байгуулах					
№	Үндсэн чиг үүрэг	Хуулийн нэр, заалт	Дэд чиг үүрэг	Хуулийн нэр, заалт	Хамтран хэрэгжүүлэгч

15	Хурлын төлөөлөгчдийн бүрэн эрхийн асуудлыг хэрэгжүүлэх	ЗЗНДНТУТХ 35.1.1.	<p>Хурлын шийдвэрийг сонгогчдодоо тайлбарлан таниулах;</p> <p>Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг даргад асуулт, асуулга тавих;</p> <p>сонгогчидтой тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлан хариуг хуульд заасан хугацаанд авах;</p> <p>үйл ажиллагаагаа жилд нэг удаа сонгогчдод тайлагнах.</p>	ЗЗНДНТУТХ 39.1.1, 39.1.2, 39.1.3, 39.1.4, 39.1.5, 39.1.6, 39.1.7, 39.1.8, 39.1.9	Ажлын алба Засаг даргын Тамгын газар
16	Хурлын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах;	ЗЗНДНТУТХ 35.1.2.	Нэр дэвшигчдийн аль нь ч олонхын санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг хоёр дахь санал хураалтад оруулах бөгөөд тэдгээрийн хэн нь ч олонхын санал аваагүй бол энэ хуулийн 53.2-т зааснаар дахин нэр дэвшүүлнэ.	ЗЗНДНТУТХ 53.1, 53.2, 53.3, 53.4, 53.4, 53.5, 53.6, 53.7	Төлөөлөгч
17	Хурлын хороог байгуулах, хорооны бүрэлдэхүүн, даргыг сонгох, өөрчлөх;	ЗЗНДНТУТХ 35.1.3.	Хороог Хурлын бүрэн эрхийн хугацаанд төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд Хорооны даргыг тухайн хорооны	ЗЗНДНТУТХ (2020), 45.2, 45.3, 45.4, 45.5, 55.3, Сумын ИТХ-ын тогтоолоор	Хороо

			<p>төлөөлөгчдийн дотроос сонгоно.</p> <p>Хороо тухайн Хуралд ажлаа хариуцан тайлагнана.</p> <p>Хурал нь судалгаа, санал, дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий бусад хороо, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.</p> <p>Хорооны үйл ажиллагааны чиглэл, тоо, бүрэлдэхүүн, түүнчлэн хороо, ажлын хэсэг байгуулах, хороог татан буулгах, тэдгээрийн ажиллах журмыг Хурал өөрөө тогтооно.</p> <p>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.</p> <p>Хорооны гишүүдэд жил бүр 50 хувийн өөрчлөлт оруулж болно.</p>	батлагдсан "Хороодын ажиллах журам"	
18	Хурлын ажлын албыг чиглүүлэх	ЗЗНДНТУТХ 54-р зүйл	<p>улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтны албан тушаал;</p> <p>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсөвтэй байх бөгөөд төсвийг Хурлын нарийн бичгийн дарга захиран зарцуулна.</p>	Төрийн албаны тухай хууль 11.1.10 ЗЗНДНТУТХ 55.1, 55.2	Ажлын алба

2.2.ХАРИЛЦАА ХОЛБООНЫ УЯЛДАА

Сумын ИТХ-ын ажлын албаны аливаа үйл ажиллагаа, шийдвэрт өртдөг эсвэл өртөх магадлалтай үндэсний, олон нийтийн, хувийн болон нийгмийн салбарын хувь хүн, бүлэг,

байгууллагыг ойлгох бөгөөд удирдлагаар хангах, хамтран ажиллах, хэрэглэгч болон гүйцэтгэгч гэсэн 4 ангиллаар тодорхойлно.

Сонирхогч талууд:

№	Сонирхогч талын нэр	Гадаад	Дотоод
1.	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	+	
2.	Монгол улсын яам, агентлаг	+	
3.	Шүүх, прокурорын байгууллага	+	
4.	Төрийн албаны зөвлөл	+	
5.	Авлигатай тэмцэх газар	+	
6.	Аймгийн Засаг даргын Тамгын газар	+	
7.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх агентлагууд, харьяа байгууллагууд	+	
8.	Аймгийн ИТХ-ын ажлын албаны нийт ажилтнууд	+	
9.	Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчид	+	
10.	Сумын ИТХ-ын дарга, ажлын алба		+
11.	Сумдын ИТХ-ын Төлөөлөгчид		+
12.	Төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллага /холбоо, мэргэжлийн холбоо/	+	
13.	Нам, олон нийт, иргэний байгууллага	+	
14.	Монгол улсын иргэн	+	
15.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл	+	
16.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл		+
17.	Хэвлэл, мэдээллийн байгууллагууд	+	

Харилцаа холбооны уялдаа:

№	Мэдээлэл	Хариуцах эзэн	Нууцлалын зэрэг	Хэнд дамжуулдаг	Ямар сувгаар	Хугацаа
1.	Сумын ИТХ-ын даргын захирамж (үндсэн үйл ажиллагааны асуудлаар)	Ч.Батчимэг	Албан хэрэгцээ	төр захиргааны байгууллагууд, иргэд, ТББ	Цахим, хэвлэл мэдээлэл, албан бичиг	Тухай бүр
2.	Сумын ИТХ-ын даргын захирамж (боловсон хүчний асуудлаар)	Ц.Ганбаяр	Албан хэрэгцээ	төр захиргааны байгууллагууд, иргэд	Цахим, хэвлэл мэдээлэл, албан бичиг	Тухай бүр
3.	Нарийн бичгийн даргын тушаал (үндсэн үйл ажиллагааны асуудлаар)	Ц.Ганбаяр	Албан хэрэгцээ	төр захиргааны байгууллагууд, иргэд	Цахим, албан бичиг	Тухай бүр
4.	Нарийн бичгийн даргын тушаал	Ц.Ганбаяр	Албан хэрэгцээ	төр захиргааны байгууллагууд, иргэд	Цахим, албан бичиг	Тухай бүр

	(боловсон хүчний асуудлаар)					
5.	Нууцын баримт бичиг	Ц.Ганбаяр	Нууц	Тагнуулын газар, Авлигатай тэмцэх газар, АЕГ, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл	Шуудан	Шаардлагатай үед
6.	Жендерийн мэдээ тайлан	Ч.Батчимэг	Албан хэрэгцээ	ЖҮХороо,	Цахим, албан бичиг	1-р улиралд
7.	Хэвлэл мэдээллийн байгууллагатай хийсэн гэрээ	Хэвлэлийн төлөөлөгч, олон нийттэй харилцах ажилтан	Албан хэрэгцээнд	Албан байгууллагууд	шуудан	Тухай бүр
8.	Ажилтнуудын хувийн хэрэг	Ц.Ганбаяр	Албан хэрэгцээнд	Төрийн албаны зөвлөл,	Шуудан	Шаардлагатай үед
9.	Сумын ИТХ-ын Стратеги төлөвлөгөө		Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, цаасан	Хугацаанд
10.	Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө		Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, цаасан	Хугацаанд
11.	Ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан		Албан хэрэгцээнд	Төрийн албаны зөвлөл,	Цахим, Цаасан	хагас жил, жил,
12.	Авлигатай тэмцэх, Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг		Албан хэрэгцээнд, нийтэд	АТГ	Шуудан, цахимаар	1-р улиралд, тухай бүр
13.	ИТХ-ын хяналт шалгалтын баримт бичиг		Албан хэрэгцээнд	төр захиргааны байгууллагууд	Цахим, шуудан, хэвлэл мэдээлэл, албан бичиг	Тухай бүр
14.	Тогтоол шийдвэрийн биелэлт	Ч.Батчимэг	Албан хэрэгцээнд	төр захиргааны байгууллагууд	Цахим, шуудан, хэвлэл мэдээлэл, албан бичиг	Улирал бүр
15.	Шагналын материал		Албан хэрэгцээнд	Байгууллагын архив, цаасан,	Цахим, шуудан, албан бичиг	Тухай бүр
16.	ИТХ-ын тогтоол		Албан хэрэгцээнд, нийтэд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, шуудан, хэвлэл мэдээлэл, албан бичиг	Тухай бүр

17.	ИТХ-ын Хуралдааны материал		Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, шуудан, албан бичиг	Тухай бүр
18.	Хуралдааны тэмдэглэл		Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, шуудан, албан бичиг	Тухай бүр
19.	Хуралдаанаас өгсөн үүрэг даалгавар		Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, шуудан, хэвлэл мэдээлэл, албан бичиг	Тухай бүр
20.	ИТХ-ын Хороодын хуралдааны материал		Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, шуудан, албан бичиг	Тухай бүр
21.	ИТХ-ын Хороодын төлөвлөгөө		Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, шуудан, хэвлэл мэдээлэл, албан бичиг	Тухай бүр
22.	ИТХ-ын Хороодын хурлын тэмдэглэл		Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, шуудан, албан бичиг	Тухай бүр
23.	ИТХ-ын хороодоос явсан бичиг		Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, шуудан, хэвлэл мэдээлэл, албан бичиг	Тухай бүр
24.	Иргэний танхим, нээлттэй хэлэлцүүлгийн материал	Хэвлэлийн төлөөлөгч, олон нийттэй харилцах ажилтан	Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, шуудан, хэвлэл мэдээлэл, албан бичиг	Тухай бүр
25.	ИТХ-ын Төлөөлөгчдөөс явуулсан бичиг		Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, шуудан, хэвлэл мэдээлэл, албан бичиг	Тухай бүр
26.	ИТХ-ын Зөвлөлийн хуралдааны материал	Ч.Батчимэг	Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, шуудан, албан бичиг	Тухай бүр
27.	ИТХ-ын Зөвлөлийн тэмдэглэл		Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, албан бичиг	Тухай бүр
28.	ИТХ-ын Зөвлөлийн тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавар		Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, хэвлэл мэдээлэл, албан бичиг	Тухай бүр
29.	Сумын ГХУСАЗЗ Гэрээ, төлөвлөгөө, ирсэн, явсан бичиг,	Ч.Батчимэг	Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, хэвлэл мэдээлэл, албан бичиг	Тухай бүр


30.	ИТХ-аас явсан бичиг	Ч.Батчимэг	Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, шуудан, албан бичиг	Тухай бүр
31.	ББНШК-ийн материал		Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, албан бичиг	Тухай бүр
32.	Байнга хадгалах нэгжийн бүртгэл		Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, шуудан, албан бичиг	Тухай бүр
33.	Түр хадгалах нэгжийн бүртгэл		Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, шуудан, албан бичиг	Тухай бүр
34.	Гэрэл зураг, дүрс бичлэгийн архив, гэрэл зургийн цомог	Хэвлэлийн төлөөлөгч, олон нийттэй харилцах ажилтан	Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, шуудан, хэвлэл мэдээлэл, албан бичиг	Тухай бүр
35.	Өргөдөл, гомдол		Албан хэрэгцээнд	Иргэд, албан байгууллагууд	Цахим, хэвлэл мэдээлэл, албан бичиг	Тухай бүр
36.	Санхүүгийн тайлан	Нягтлан бодогч Н.Мядагма а	Албан хэрэгцээнд	Албан байгууллагууд	Цахим, шуудан	Тухай бүр
37.	ХОААТ-ын тайлан		Албан хэрэгцээнд	Албан байгууллагууд	Цахим, шуудан	Тухай бүр
38.	Нийгмийн даатгалын тайлан		Албан хэрэгцээнд	Албан байгууллагууд	Цахим, шуудан	Тухай бүр
39.	Төсвийн гүйцэтгэл сар бүр		Албан хэрэгцээнд	Албан байгууллагууд	Цахим, шуудан	Тухай бүр
40.	Нэмэлт санхүүжилтийн харилцах		Албан хэрэгцээнд	Албан байгууллагууд	Цахим, шуудан	Тухай бүр
41.	Үндсэн хөрөнгийн тайлан	Нягтлан бодогч Н.Мядагма а, нярав Б.Батбаяр	Албан хэрэгцээнд	Албан байгууллагууд	Цахим, шуудан	Тухай бүр
42.	Бараа материалын тайлан		Албан хэрэгцээнд	Албан байгууллагууд	Цахим, шуудан	Тухай бүр

2.3.ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ


ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
<p>1.Орон нутагт тулгарч байгаа асуудлаа өөрсдөө бие даан шийдэх боломжтой.</p> <p>2.Хурлын үйл ажиллагаа тасралтгүй, тогтмол зохион байгуулагддаг.</p> <p>2.Төлөөлөгчдөөс сумын гүйцэтгэх засаглалыг тэргүүлдэг.</p> <p>4.Төсөв харьцангуй боломжтой</p> <p>5.Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ хүртээмжтэй.</p> <p>6.Хурлын төлөөлөгчид болон иргэдэд хүргэх мэдээллийг цахимаар тогтмол хүргэдэг.</p>	<p>1.Хэлэлцэх асуудлыг бүрэн уншиж судалдаггүй. Асуудал оруулж буй этгээд хугацаа тулган материал өгдөг.</p> <p>2.Хорооны ажилд бүрэн оролцдоггүй.</p> <p>3.Хуульд заасан эрх, үүргээ бүрэн мэддэггүй.</p> <p>4.Сонгогдсон төлөөлөгчдийн хандлага харилцан адилгүй.</p> <p>5.Нутгийн удирдлагаар мэргэшсэн хүний нөөц хомс.</p> <p>6.Хурлын хороо, зөвлөлийн ажил тогтмолжоогүй.</p> <p>7.Гаргасан шийдвэрт хяналт үнэлгээ хийх</p>

<p>7.Төлөөлөгч болон ажлын албаны албан хаагчдыг мэргэшүүлэх чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулдаг. Хамт олны эерэг таатай уур амьсгалтай</p>	<p>тогтолцоо муу. 8.Байгалийн давагдашгүй хүчин зүй тулгарахад малчид болон иргэдэд төрийн болон тусламжийн үйлчилгээг хүргэхэд албаны машин хуучин тул эвдрэл гэмтэл байнга гардаг 9.Хурлын ирц 100% бүрэлддэггүй 10.Мэдээллийн аюулгүй байдал (Цахим болон цаасан баримт бичгийн хадгалалт хамгаалалт муу, баримт бичиг алга болдог аюултай)</p>
БОЛОМЖ	ЭРСДЭЛ
<p>1.Төсвийн эрх мэдэл нэмэгдсэн. 2.Иргэдийн НӨУБ-ыг ойлгох хандлага сайжирч байгаа. 3.Төлөөллийн ардчиллын зарчмыг хослуулан шийдвэр гаргах боломж бүрдэж байгаа. 4.Мэдээлэл солилцох боломж нэмэгдсэн. 5.Иргэд, ТББ-ууд шийдвэрийн төсөлд саналаа тусгуулах боломж бүрдсэн.</p>	<p>1. УИХ-ын сонгуулийн үр дүнгээс хамаарч ИТХ-ын үйл ажиллагаанд хүндрэл үүсдэг. 2.Нутгийн ӨУБ-ын үйл ажиллагааны талаар иргэд олон нийт харилцан адилгүй ойлголттой НӨУБ-д хандах хандлага бүрэн төлөвшөөгүй. 3.Үйл ажиллагаанд улс төрийн нөхцөл байдал нөлөөлөх. 4.Сонгогдсон төлөөлөгчдийн асуудалд хандах хандлага харилцан адилгүй. Зөвхөн өөрийн сонгогдсон тойргийн асуудлыг хөндөх. 5.Эдийн засгийн хувьд хараат. 6.ИТХ, ИНХ харилцан уялдаа, хамтын ажиллагаа сул. 7.Бодлого боловсруулах түвшинд иргэдийн нийтлэг эрх ашиг хангагдахгүй байх.</p>


**2.4. СУМЫН ИТХ, АЖЛЫН АЛБАНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
НУТГИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГА, НУТГИЙН ЗАХИРГАА**



ИТХ БА ЗАСАГ ДАРГЫН ХООРОНДЫН ХАРИЛЦАА



**СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ**



СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН АЖЛЫН АЛБАНЫ ЧИГ ҮҮРЭГ

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хурлын зөвлөл, төлөөлөгчид, хороод, Хурлын дэргэдэх зөвлөл, ажлын хэсгүүдийн үйл ажиллагааг нэгтгэн зохицуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үйл ажиллагаанд нь дэмжлэг туслалцаа үзүүлж, удирдлагаар хангаж ажиллана.
2. Хурал, Хурлын зөвлөл, хороодын хуралдааны бэлтгэл ажлыг хангаж хуралдуулна.
3. Хуралдаанд хэлэлцүүлэхээр оруулж байгаа төслийг хянаж, зохих журмын дагуу бэлтгэлийг хангуулах, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын шийдвэр, баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах, хүргүүлэх, түүний биелэлтэд хяналт тавьж, нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна.
4. Хурлын болон Хурлын зөвлөл, хороодын хуралдааны тэмдэглэл, санал дүгнэлтийг хөтөлж, уг тэмдэглэл, санал дүгнэлтийг холбогдох байгууллага, газарт уламжлах, хадгалах ажлыг эрхлэн явуулна.
5. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг эрхэлнэ.
6. Хуралдаанаар батлагдсан шийдвэрийг албажуулах, нийтэд ил тод мэдээлэх ажлыг зохион байгуулна.
7. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олон нийттэй харилцах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагааг ил тод нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулна.
8. Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, шийдвэрлүүлэхээр уламжлах, эргэж мэдээлэх, дүнг Хурлын дарга, холбогдох хороонд танилцуулах ажлыг зохион байгуулна.
9. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны Хөдөлмөрийн дотоод журмыг Хурлын даргын захирамжаар батлан мөрдүүлнэ.
10. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг хангаж, Монгол улсын Засгийн газраас баталсан цалингийн сүлжээний дагуу цалинжуулах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулах, хууль журмын дагуу ээлжийн амралт олгох, ажлын гүйцэтгэлээр шагнаж урамшуулах, хариуцлага тооцох, нийгмийн баталгааг хангаж, хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж ажиллана.
11. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг дарга, Засаг даргын орлогч, Багуудын Засаг дарга, ажлын албаны төрийн албан хаагчдын Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргуулан авах, хяналт тавих, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар зөвлөмж өгөх, мэдээлэл, тайланг холбогдох байгууллагад хуулийн хугацаанд мэдүүлж ажиллана.
12. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны даргын чиг үүрэг:

1. Ажлын албаны дарга нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааг Хурлын даргын өмнө хариуцаж, ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд удирдлага зохион байгуулалтаар хангана.
2. Хурлын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Хурлын даргаар батлуулан, ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, тэдгээрийн хэрэгжилт, үр дүнг хянана.
3. Хурлын байгууллагаас Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Засаг захиргаа, төрийн үйлчилгээний болон сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, албан тушаалтантай харилцах ажлыг нэгтгэн зохион байгуулна.
4. Ажлын албаны хүний нөөцийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, хяналт тавих, албан тушаалын тодорхойлолт, түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж боловсронгуй болгох арга хэмжээ авна.
5. Иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдол, маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх ажлуудыг нэгтгэн зохион байгуулж, хяналт тавина.

6.Ажлын албаны ажилтан, албан хаагчдын санал, хүсэлтийг хүлээн авч, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах нөхцөл, бололцоог бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.

7.Ажлын албаны албан хаагчдын ёс зүй, ашиг сонирхлын байдалд хяналт тавьж, энэ талаар гарсан гомдол мэдээллийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлнэ.

8.Ажлын албаны дунд хугацааны бодлогын баримт бичиг, төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн гүйцэтгэлийг хангуулна.

9.Байгууллагын дотоод зохион байгуулалт, дэг журам, соёл, эмх цэгцийн асуудлыг нэгтгэн зохицуулна.

-000-